

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр, Лхагва гараг**

|                                          |      |
|------------------------------------------|------|
| <b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>   | 1    |
| <b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>        | 2-2  |
| <b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b> | 3-10 |

- 
- |                                                                                                                                                                                       |      |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
| <b>1. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд<br/>нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл<br/>/Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн,<br/>эцсийн хэлэлцүүлэг/</b> | 3-10 |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
-

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы  
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны  
12 дугаар сарын 10-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 30 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, С.Ганбаатар, Х.Ганхуяг, Д.Жаргалсайхан, С.Лүндэг, Л.Мөнхбаясгалан, Т.Мөнхсайхан, Ц.Туваан, А.Ундраа, Ж.Чинбүрэн.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, Ц.Идэрбат нар үг хэлэв.

**Нэг.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, мөн яамны Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Б.Гарамханд, “Үндэсний давхар даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Жавхлант, мөн компанийн Эрсдэлийн удирдлагын ахлах ажилтан П.Шинэзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Б.Энхгэрэл нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Байнгын хорооны дарга Б.Бейсен танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг, Г.Ганбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, “Үндэсний давхар даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирал Б.Жавхлант нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 30 минут үргэлжилж, 30 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 63.3 хувийн ирцтэйгээр 13 цаг 00 минутад өндөрлөв.

**Тэмдэглэлтэй танилцсан:**

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,  
ХӨДӨӨ АЖ АХУЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр, Лхагва гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
12 цаг 30 минут.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Бейсен:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 53,3 хувьтай бүрдсэн тул 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хуралдааны ирцийг танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар гишүүн ирсэн байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. Сонгобайн Замира гишүүн ирсэн байна. Мэндбаярын Мандхай гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Гомбын Ганбаатар гишүүн ирсэн байна. Жаргалсайханы Золжаргал гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн ирсэн байна. Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн байна. Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна. Баатаржавын Мөнхсоёл гишүүн ирсэн байна. Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025 оны 1 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэх асуудалтай саналтай гишүүн байна уу. Ганбаатар гишүүнээр тасаллаа. Хэлэлцэх асуудалтай холбоотой Ганбаатар гишүүн асуулт асууя.

**Г.Ганбаатар:** Өдрийн мэнд. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд уг нь овоо дорвитой өөрчлөлт орох болов уу. Дээрээс нь өнгөрсөн 2023 оны зудаас бас сургамж аваад, малчид ч гэсэн энэ даатгалд хандах хандлага нь арай өөрчлөгдөх болов уу. Нөгөө талдаа төр засгаас бас энэ Хөдөө аж ахуйн салбар ялангуяа энэ Мал аж ахуйн салбарт энэ эрсдэлийг бууруулахад энэ их даатгалд их чухал даатгал. Дээрээс нь Засгийн газраас өргөн барьсан хэлбэр дээр нь бас Улсын Их Хурал ярилцаад, овоо өөрчлөлт орчих болов уу гэсэн олигтой, дорвитой өөрчлөлт орохооргүй ийм танилцуулга эцсийн хэлэлцүүлэгт өргөн барих гэж байгаа юм байна. Тэгэхээр энэ даатгал хөдөө аж ахуй, мал аж ахуйн салбарын энэ эрсдэлийг бууруулах асуудал дээр ахиж цаашдаа Их Хурлын гишүүд өөрсдөө санаачлаад юм уу эсвэл өөрсдөө энэ даатгалын хуульд эсвэл тусгай хууль байдаг юм уу тийм арга хэмжээ авахгүй бол энэ бол олигтой юм болсонгүй шүү. Өчнөөн ажил болоод тэгээд Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд хуучин 6 хувь байсан босго үзүүлэлт 5 хувь болсон байна.

Дээрээс нь тэр нөгөө урьдчилсан нөхөн олговор гэж ер нь бол даатгал чинь хохирол гарсан л бол тухай бүрдээ олгож л байх ёстой систем юм чинь. Тэгээд ийм индексжүүлсэн гэдэг эсвэл нэрээ авах байсан юм уу. Ер нь энэ мал аж ахуйн даатгалын тухай асуудал бол энэ дээр дорвитой өөрчлөлт орж чадсангүй. Анх энэ чинь ийм түүхтэй юм билээ. Одоо тэр сая бид Байнгын хорооны ирц хүрэхээс өмнө бид нар энэ тухай ярилцаад байж байна лээ. Идэрбат дарга бид нар. Энэ анх Үндсэн хуульд орсон заалт нь хөдөө аж ахуйн эрсдэл нь мал аж ахуйн эрсдэлийг хамгаалах гээд тэр 1992 оны Үндсэн хууль хэлэлцэж байх үед Өмнөговь аймгийн Гурвантэс сум, 261 дүгээр тойргоос сонгогдсон Пүрэв гэдэг хүн анх мал аж ахуйн талаар энэ Үндсэн хуульд ялангуяа мал аж ахуйн эрсдэлийн талаар огт заалт орсонгүй гэж. 2 дахь нь Сүхбаатар аймгийн Асгат сумаас сонгогдсон Цог-Очир гэж хүн бас энэ талаар ер нь мал сүрэг бол үндэсний баялаг байна. Мал сүрэг бол манай эдийн засгийн гол зүйл байна. Тийм учраас энэ чиглэлээр Үндсэн хуульд оруулах ёстой гээд, тэгээд яг Үндсэн хуулийн агуулга нь ч гэсэн тийм юм билээ. Тэр Лүндэндорж гуайн Үндсэн хуульд ёсонд шинжлэх ухааны тайлбар тэр анхны 1992 оны Үндсэн хууль тухайн үед хэлэлцэж байсан бүх протоколыг нь би уншсан л даа. Одоо манай туслах наашаа оруулаад ирэх байх. Уг нь би энийг чинь арай ийм хурдан ийм маягаар явчихна ч гэж бодсонгүй. Тэгэхээр ерөөсөө төрийн хамгаалалтад байна гэдэг заалт нь хэрвээ энэ даатгалтайгаа уялдах юм бол тодорхой хувийг нь төр ч гэсэн хариуцах ёстой юм байна лээ. Даатгалын хураамж нь тэгж байж л нэг арай гайгүй болохоос биш малчид тодорхой хувиа даатгуулж сурах ёстой. Малчид тодорхой хувиа өөрсдөө хариуцах ёстой. Тэр Үндсэн хуулийн заалт үнэхээрийн тэр агуулгаараа хэрэгжих юм бол тэр шинжлэх ухааны тайлбар толь дээр бичигдсэнээсээ хэрэгжих юм бол төр ч гэсэн энэ эрсдэлийг нь хуваалцах ёстой юм байна лээ шүү. Ийм маягаар энэ хууль явах болов уу гэж бодсон. Тухайн үедээ ч гэсэн би Байнгын хороодын хурал дээр энэ хуулийг хэлэлцэж байх үед нь байр сууриа яг иймэрхүү агуулгаар илэрхийлж байсан. Тэгээд ..../минут дуусав/

**Б.Бейсен:** Ганбаатар гишүүн сууя.

**Г.Ганбаатар:** Гишүүдээс бас хүсэхэд цаашдаа ч гэсэн энэ Малын даатгалын тухай хуулийг зүгээр малын индексжүүлсэн гэхгүйгээр Мал аж ахуйн салбарын даатгалын тухай хууль гэдэг юм уу тусгай хууль гарахгүй бол энэ бол олигтой юм болсонгүй. Өчнөөн ярьж, өчнөөн хэлэлцэж хэлэлцэж, тэгээд ийм маягаар танилцуулгыг нь Улсын Их Хурлын чуулган руу эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлж байгаа бол харамсалтай байна гэдгийг энэ дашрамд хэлье.

**Б.Бейсен:** Ажлын хэсгийн ахлагч Идэрбат гишүүн хариулъя.

**Ц.Идэрбат:** Ганбаатар гишүүнтэй бас зарим нэг зүйл дээр санал нэг байгаагаа хэлэх нь зүйтэй байх. Гэхдээ энэ бол юу гэдэг юм гишүүдийн зүгээс өргөн бариад санаачлаад явчихсан хууль биш. Энэ бол Засгийн газраас өргөн барьсан хуулийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанд хуралдуулах бэлтгэл ажлыг хангах үүрэгтэй л ажлын хэсэг. Бидний ажлын хэсгийн хүрээнд ямар хүрээнд ярих вэ гэдэг нь өөрөө бас хуулийн зохицуулалттай. Бид Засгийн газрын өргөн барьсан тэр хуулийн хүрээнд л ярих үүрэгтэй. Тэрнээс энэ хуулийг бүхлээр нь өөрчлөөд явах тийм эрх зүйн бололцоо бидэнд бол байхгүй. Засгийн газраас өргөн барьсан энэ хуулийн төслүүдийг аль болох малчдын хэлдэг, ярьдаг тэр зүйл рүү бас дөхүүлэхийг хичээсэн. Хугацаа бас нэлээдгүй орсон. Хугацаа орсон шалтгаан бол таны зарим зүйлүүдтэй яг нэгдэж байгаа. Юу гэхээр бидний өнөөдрийн оруулж ирж байгаа энэ хуулийн төсөл яг малын индексжүүлсэн даатгал гэдэг энэ даатгалын системийг бас малчдын хүссэн хэмжээнд аваачиж чадахгүй байна. Тийм учраас тэр хэмжээнд

дөхүүлэхийн тулд бас энэ өргөн барьсан хуулийн хүрээнд биш, дахиад хажууд нь шинэ хууль өргөн барих ёстой юм байна гээд нэр бүхий улс төрийн намуудын 5 намаас бүрдсэн 10 гишүүн Засгийн газарт бас саналаа илэрхийлээд, хуулийн төсөлд санал авсан. Харамсалтай нь хавар явуулсан санал маань намар 10 сард дэмжих боломжгүй гэдэг ийм дүгнэлт Засгийн газрын тэмдэглэлээр ингэж орж ирсэн. Тийм учраас энэ 2 хуулийг нэгтгээд явуулах бололцоо болоогүй учраас Засгийн газрын өргөн барьсан хуулийнхаа хүрээнд энэ асуудал ингээд явж байгаа юм. Цаашдаа яг таны хэлж байгаа энэ малын индексжүүлсэн даатгал байх уу, хөдөө аж ахуйн даатгал байх уу, мал аж ахуйн даатгал байх уу ийм хуулийг шинэчлэх, санаачлах энэ эрх бол Их Хурлын гишүүдэд бүрэн байгаа. Нээлттэй байгаа. Ер нь яах вэ зүгээр энэ индексжүүлсэн даатгалын асуудлыг ярихын тулд Монголын хөдөө аж ахуйн салбарын даатгалын түүхийг эргээд харахаар яг одоо бидний хүсэн хүлээж байгаа магадгүй автомашины жолоочийн албан даатгал шиг тийм зүйлүүдийг хийх гэж Монгол Улсын төр бас 1968 оноос 1980 он хүртэл бас ноцолдсон юм билээ. Тэгээд тэр үед бол мал нь ч төрийн өмч, даатгагч нь ч төрийн өмч л байсан. Гэхдээ яг хотонд гаргасан хорогдлоор бас шийдэж чадахгүй яваад, 1988 онд байх аа энэ нь хүчингүй болоод, тэгээд 2005 он хүртэл бол ямар ч ийм даатгалын систем байхгүй байж байгаад Дэлхийн банкны санхүүжилтээр эхлээд төсөл хэрэгжиж явж байгаад 3, 3 аймгууд нэмэгдэж байгаад 2014 онд хуультай болоод 11 жил хэрэгжиж байгаа ийм л хууль байгаа. Амьдрал дээр нийцэхгүй байгаа юм бас байгаа юу гэвэл бас байгаа гэдэгтэй бол би санал нэгдэнэ. Энэ хуулийг .... миний 1 минутыг нэмж өгч өгөх бололцоо байгаа тийм ээ. Энэ хууль дээр тэр малчдын яах вэ, малын индексжүүлсэн даатгалтай холбоотой асуудлаар малчдын санал, хүсэлтийг сонсоход бол 1 дүгээрт бол нөгөө хувийн асуудал ярьдаг. Хувь бол энэ чинь бид нар чинь том газар нутагтай, 1 аймаг доод тал нь 16, 17, дээд тал нь 20 гаруй сумтай. Аймгийн хэмжээнд нэгдсэн хувь гаргаад байх нь зудад автчихсан, мал нь хорогдчихсон сумын иргэд хохирох ийм нөхцөл байдал бүрдээд байгаа. Дээрээс нь мал хорогдсон ч гэсэн хувь 6 гэдэг өндөр хувьтай байна гэдэг ийм гомдлыг малчид ярьдаг. Энэ хөндөгдөөд яг 5 ч бас биш юм. 4, 5 максимумдаа 6 гэж байгаа. Тэгэхээр энэ бол бас тодорхой хэмжээнд 6 хувь биш 4 хувь болгож буулгана гэдэг бол бас 1 үр дүн гэж ингэж бас харж байгаа.

Нөгөө талдаа урьдчилж олгоно гэдэг энэ зүйл бол өмнө нь байгаагүй. Өмнө нь байгаагүй. 6 сарын мал тооллогоор малынхаа хорогдлыг бодуулсан, тооцуулсан малчин 10 сар, 11 сард дансандаа мөнгөө авдаг. Энийг нь бол мал ядарч эхэлж байх үед нь хорогдол ..../минут дуусав/

**Б.Бейсен:** Хэлэлцэх асуудалд оръё.

**Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.**

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Болорчулуун Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Сангийн яамнаас Амарбаясгалан Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга, Б.Гарамханд Санхүүгийн бодлогын газрын Санхүү зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн, “Үндэсний давхар даатгал”-ын газраас Б.Жавхлант Гүйцэтгэх захирал, П.Шинэзул Эрсдэлийн удирдлагын ахлах ажилтан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 12 дугаар сарын 4, 5-ны өдөр нэгдсэн хуралдаанаар Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгын төслийн бэлтгэн та бүхэнд тараасан.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон танилцуулгын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу. Нэрс өгнө үү. Гомбын Ганбаатар гишүүнээр тасалъя. Ганхүлэг гишүүний асуулт асууя.

**М.Ганхүлэг:** Тодорхой 2 асуулт асууя. Засгийн газрын өргөн барьсан төслийн дагуу бас тодорхой бас өөрчлөлтүүдийг орж ирж байгаа гэж ойлгож байгаа. Өмнө нь бас ажлын хэсгийн даргын дурдсан, Засгийн газарт өргөн барьсан 10 гишүүдийн хуулийн төсөлтэй холбогдолтой ийм мэдээлэл бас байгаа. Тэгэхээр энэ хуулийн төсөл бас ер нь ямаршуу агуулгын хүрээнд байсан бэ. Дэмжигдээгүй шалтгаан, энийг ер нь энэ хуулийн төслийг бас цаашдаа илүү анхаарах чиглэлийн асуудал бас яригдаж эхэлж байх шиг байна. Тэгээд энэ дээр нэмэлт бас тайлбар юмнууд авъя.

2-т нь ажлын хэсгээс ер нь өнөөдрийн орж ирж байгаа тодорхой зохицуулалт бол бас бүрэн энэ асуудлыг шийдэж чадахгүй байна гэдэг дээр Байнгын хорооны гишүүд бас саналтай байх шиг байна. Тэгэхээр ер нь цаашдаа энэ өөрчлөлтөөс гадна бас ямар суурь өөрчлөлтүүдийг бас бид хийж болох вэ гэсэн ерөнхий ийм 2 асуултаар хариулт авъя.

**Б.Бейсен:** Идэрбат гишүүн хариулъя.

**Ц.Идэрбат:** Нэр бүхий 10 гишүүн бас хуулийн төсөл санаачлаад, саналаа Засгийн газарт явуулсан. Засгийн газраас бол дэмжээгүй. Дэмжээгүй учир шалтгаан бол маш жоохон шалтгаан байгаа юм байна л гэж ингэж харж байгаа юм. Энийг бид засаад, цааш нь боловсруулаад ингээд явах, дахиж өргөн барих ийм бололцоо бол байгаа. Тэр ямар агуулгатай байна вэ гэхээр ер нь малын индексжүүлсэн даатгалын хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулж, энэ гамшгийн эрсдэлийн сан гэдэг зүйлийг бас бий болгож, давхар даатгалаас гадагшаа урсаж байгаа сан хөрөнгийг зөвхөн гадагш нь биш дотооддоо авч үлдэх, тэрийг мал аж ахуйн салбар луугаа татах, эрсдэлийг давхар даах гээд олон зүйлүүдийг бас төлөвлөсөн ийм хуулийн төсөл байгаа гэдгийг 1 дүгээрт бас хэлье.

**Б.Бейсен:** Ажлын хэсгээс хэдэн номер хариулах вэ. 5 номерын микрофон.

**Б.Жавхлант:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. “Үндэсний давхар даатгал” компанийн гүйцэтгэх захирал Жавхлант. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль тогтолцооны хувьд бол яг суурь тогтолцоо бол яг одоогийн байдлаар өргөн барьсан хуулийн хүрээнд бол тогтолцооны хувьд бол өөрчлөлт ороогүй байгаа. Үндсэндээ хувийн хэвшлийн даатгалын 7 даатгалын компани энэ даатгалын бүтээгдэхүүнийг 21 аймагт борлуулдаг. Хувийн даатгалын компани орж байгаа цорын ганц шалтгаан бол 1 дүгээрт индексэд суурилсан даатгалын тогтолцоо явж байгаа.

2 дугаарт нь давхар даатгал буюу гамшгийн эрсдэлийг нь “Үндэсний давхар даатгал” компани буюу төрийн эзэмшлийн давхар даатгалын компани хариуцаж байгаа учраас эрсдэлийн хувьд дааж хүлцэх боломжтой гэдэг утгаар хувийн хэвшил энэ даатгалын тогтолцоог индексэд суурилсан даатгалын тогтолцоог дэмжиж явдаг. Олон улсын жишгийг аваад үзэх юм бол гамшгийн эрсдэлийн даатгалыг индексэд суурилсан хэлбэрээр олон улсад хэрэгжүүлдэг ийм түгээмэл зүй тогтолтой байдаг. Ялангуяа Хөдөө аж ахуйн даатгалын хувьд бол яг энэ цаг уурын болон бусад хүчин зүйлүүд дээр тулгуурласан индексэд суурилсан хөдөө аж ахуйн даатгалын бүтээгдэхүүнүүд бол олон улсад хамгийн түгээмэл хэлбэртэй оршдог.

Монгол Улсын хувьд бол малын индексжүүлсэн даатгалын тогтолцоо бол яг олон улсын жишигт Монголын нөхцөлд ганцхан хэрэгжиж байгаа. Том малын зүй бус хорогдолд суурилсан дэлхийд цөөхөн газарт байдаг нүүдлийн соёл иргэншил, уламжлалт мал аж ахуйтай энэ газруудаас бол Монгол Улсад бол хамгийн түгээмэл, хамгийн амжилттай хэрэгжиж байгаа төслүүдийн 1 гэж дүгнэгддэг.

**Б.Бейсен:** Идэрбат гишүүн нэмээд хариулъя.

**Ц.Идэрбат:** Яах вэ, зүгээр манай Монголд байгаа даатгалын системүүдийг харахаар албан журмын даатгал, өөрийнхөө сонирхлоор даатгадаг гээд янз янзын төрлүүд байна шүү дээ. Энэ хөдөө аж ахуй дээр болоод ирэхээр малын индексжүүлсэн даатгал гээд ирэхээр нөгөө малын хорогдлыг аймгаар нь хорогдлыг тооцоод, үнэхээр хорогдол учирчээ гээд нөхөн төлбөр олгодог. Тэр нөхөн төлбөр олгох хэмжээ бол тухайн малчны өөрийнх нь даатгасан даатгалын хэмжээнээс шалтгаалж байгаа. 150 мянган төгрөг өгөөд 350, 400 болгоод авч байгаа ч хүн байж л байна. 5 саяар даатгаад 80 саяыг авч байгаа тохиолдол ч бас гарч л байдаг ийм л зүйл юм билээ. Яг малчдын хувьд бол энэ даатгалыг сайн дурын үндсэн дээр даатгаж байгаа. Нөгөө талдаа бол хотондоо хорогдсон малынхаа тоогоор авмаар байдаг. Жил болгон даатгалд мөнгө төлдөг. Тэгээд нөгөө зуд болоогүй, хорогдол гараагүй учраас гээд ингээд нөхөн төлбөр олгогдохгүй..../минут дуусав/

**Б.Бейсен:** Идэрбат гишүүн 1 минутад нэмж хариулъя.

**Ц.Идэрбат:** Тийм зүйл бас гардаг. Тэгээд олон зүйлүүд байгаа. Ер нь бол цаашдаа хөдөө аж ахуйн, мал аж ахуйн салбарын эрсдэлийг бид зөвхөн зуд гэдэг энэ зүйлээр бас төсөөлж болохгүй байна. Үнэхээр малын хорогдлыг хорогдол ихээр тарьж байгаа ол хүчин зүйлүүд болох зуд ган, аянга цахилгаан, үер ус, малын өвчин гээд энэ олон зүйлүүдийг бас давхар даатгалд хамруулах зайлшгүй шаардлага бол бий болжээ. Энэ хууль, энэ төсөл хэрэгжиж эхлэх, хууль хэрэгжиж эхлэх тэр цаг үед бол ялангуяа энэ зудын гамшиг бол улс орны эдийн засаг, ажиллах хүч, олон зүйлүүд дээр маш их сөргөөр нөлөөлж байсан ийм л зүйл юм билээ. Сая 2023, 2024 оны энэ зудаар гэхэд чинь 1,6 их наяд төгрөгийн хохирол учирлаа шүү дээ. Тэгэхээр энэ мэтийг давж гарах тийм даатгалын системийг, тогтолцоог бид нар бүр сайн болгохгүй бол яг энэ индексжүүлсэн даатгалынхаар бол цаашаа явах тэр хүсээд байгаа хэмжээнд очих бол .../минут дуусав/

**Б.Бейсен:** Гомбын Ганбаатар. Ганхүлэг гишүүн тодруулъя.

**М.Ганхүлэг:** Зудаас гадна бас бусад төрлийн хохирлууд дээр нээрээ яаж үйлчлэх вэ гэдгийг бас дахиад яг салбарынхнаас хариулаад өгөөч. Жишээлбэл бас янз бүрийн аянга цахилгаан, түүнтэй холбогдолтой асуудлууд бас зөвхөн зурвасхан

газрууд дээр бас үйлчлээд байна шүү дээ. Тэгэхээр энэ түүнтэй холбогдолтой асуудал дээр бас ер нь энэ хуулийн өөрчлөлтүүд бас яаж явах вэ гэдгийг. Ер нь бас энэ хуулийн төсөл яригдаж байгаатай холбогдолтой гишүүдийн санаачилсан тэр тодорхой бас эрсдэлийн санг бий болгоод, асуудлыг бас сууриар нь шийдээд явах асуудлыг нэлээн хөндөж бас ярилцах, энэ хууль батлагдсантай холбогдолтой хэрэгжүүлэх арга хэмжээ энэ тэр дээр бас дурдаад явах нь зүйтэй санагдаж байна гэж бас хэлэх байна.

**Б.Бейсен:** Хэдэн номер хариулах вэ. 5 номерын микрофон.

**Б.Жавхлант:** Одоогийн байж байгаа бид нарын тогтолцоо бол хагас жилийн мал тооллогын дүн буюу жилийн эцсийн мал тооллогын дүн, хагас жилийн мал тооллогын дүнгийн зөрүүгээр том малын зүй бус хорогдлын тоог тооцож нөхөн төлбөрийг олгож байгаа. Яг индексэд суурилж байгаа тохиолдолд том малын зүй бус хорогдлын тоон дээр үндэслэж байгаа тохиолдолд яг энэ бид нарт байж байгаа техникийн боломж бол жилийн эцэс, хагас жилийн мал тооллогын тооны зөрүүгээр нөхөн төлбөрийг том малын зүй бус хорогдлын тоог гаргаж баталгаажуулж, нөхөн төлбөрийг олгох техникийн боломж бололцоо бол байгаа юм.

Бусад төрлийн аянга цахилгаан, үер ус гэсэн энэхүү гамшигт үзэгдлийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх тохиолдолд бол энэ малын даатгалын уламжлалт хэлбэр буюу малыг зүсэлж даатгах ийм даатгалын бүтээгдэхүүнийг бол гаргах шаардлага болдог. Энэ дээр бол хувийн даатгалын компаниуд уламжлалт хэлбэрээр .../минут дуусав/

**Б.Бейсен:** Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууя.

**Г.Ганбаатар:** Би Жавхлант захирлаас 2 асуулт асууя.

1 дүгээрт нь яг энэ даатгалын хуулийг энэ малын индексжүүлсэн даатгалын хуулийн төсөл хэлэлцэж байх үед л би анх байр сууриа илэрхийлж байсан. Тэгэхээр энэ мал сүрэг үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна гэдэг энэ Үндсэн хуулийн 5 дугаар заалтыг юу гэж ойлгож байгаа юм бэ. Тэр Лүндэндорж гуайн Үндсэн хуулийн шинжлэх ухааны тайлбар толийг ер нь уншсан уу. Дээрээс нь яг Үндсэн хуулийг энэ заалтыг оруулсан тэр Пүрэв, ахиад хэн байгаа билээ Сүхбаатарын Асгатын Цог-Очир гэж байгаа юм. Яг энэ чинь бол малын өвчин, мал эмнэлэг, дээрээс нь гамшиг, дээрээс нь байгалийн бэрхшээл бүгдийг нь тусгаад яг Үндсэн хуульд энэ агуулгаараа орсон юм байна лээ шүү дээ. Тэгээд миний анх хэлж байсан өөрийг чинь бас тухайн үед хэлэлцэж байхад чинь хэлж л байсан. Энэ Үндсэн хуулийн заалттай юм бол төрийн оролцоо гэдэг юмыг нь яаж ойлгох юм бэ. Даатгал дээр нь сан үүсгэх юм уу эсвэл тодорхой хувийг нь даатгалынх нь 50 хувийг нь ч юм уу. Ядаж малчин иргэн 50 хувь нь байлаа гэхэд тэр төлбөрийг нь төлдөг систем байх юм уу. Танай “Үндэсний давхар даатгал” бол яг 2023 оных шиг зуд болоход бол дийлдэхгүй л дээ. Та нар давхар даатгалтай юу гадагшийгаа. 2 дахь асуудал нь болохоор ер нь энэ чиглэлийн туршлага судалсан уу. Манайх шиг ийм өвөрмөц нүүдлийн аж ахуй өөр хөдөө аж ахуйн ийм тусгай хуулиар зохицуулагдсан даатгал байсан уу. Ийм 2 асуултад хариулт авъя даа.

**Б.Бейсен:** 5 номерын микрофон хариулъя.

**Б.Жавхлант:** 1 дүгээрт нь мал сүрэг үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна гэсэн энэ Үндсэн хуулийн зохицуулалт бол мал сүрэг буюу

уламжлалт мал аж ахуй, нүүдлийн соёл, иргэншил бол төрийн хамгаалалтад байна гэсэн маш өргөн утга агуулгатай ийм зүйл заалт гэж би ойлгодог. Тийм учраас төрийн зүгээс авч хэрэгжүүлж байгаа олон арга хэмжээний зөвхөн 1 хэсэг нь энэ даатгалын тогтолцоо гэж ойлгодог. Тийм ч учраас малын индексжүүлсэн даатгалын тогтолцоогоор гамшгийн эрсдэлийн дараах санхүүжилтийн тогтолцоог бий болгох оролдлогыг 2005 оноос хийж эхэлсэн нь 2014 онд хууль болж батлагдсан гэж ойлгодог.

Манай компани бол эрсдэлээ олон улсын давхар даатгалын компани цааш нь дахин давхар даатгадаг. Үндсэндээ бол бид нар 2005 оноос хойш дэлхийн том Scor болон Swiss Re гэсэн компаниудад өөрийнхөө эрсдэлийг давхар даатгаж явсан түүхтэй. 2014 оноос 2024 оны тоог аваад үзэх юм бол нийтдээ малчдаас 36 тэрбум төгрөгийн хураамж цуглуулаад 29,4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг малчин иргэдэд олгосон байгаа. Сүүлийн 3-хан жилийн хугацаанд бол 21 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг даатгуулагч малчдадаа ер нь олгосон. Нийт энэ дүнгээс аваад үзэх юм бол гамшгийн эрсдэлийн даатгалын санг анх бүрдүүлсэн энэ хуулийн тогтолцоо бол зөвхөн төрийн биш хувийн хэвшил болон төр, хувийн хэвшлийн хамтарсан зарчмаар хамтын эрсдэлийн санг энэ хуулийн дагуу бий болгож чадсан. Үүний анхны санхүүжилт буюу “Үндэсний давхар даатгал” компанийн дүрмийн сан болон алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгө оруулалтыг Засгийн газраас хөрөнгө оруулж, “Үндэсний давхар даатгал” компани үүсгэн байгуулагдсан. Одоогийн байдлаар Хамтын эрсдэлийн сан болон “Үндэсний давхар даатгал” компани хамтраад малчид даатгалынхаа нөхөн төлбөрийг цаг алдалгүй, хуулийн дагуу олгож явж байгаа. Төрийн оролцоо бол 30-аас дээш хувийн буюу 2 дугаар босго үзүүлэлтээс дээш давсан гамшгийн эрсдэлийн дээд түвшний хохирлыг “Үндэсний давхар даатгал” компани өөрийн хөрөнгөөр буюу өөрийнхөө эх үүсвэрээр нөөцийн сан бүрдүүлж, нөхөн төлбөрийг олгож байгаа.

Дунд түвшний эрсдэлийн санг болохоор зэрэг даатгалын компани, давхар даатгалын компани хамтраад, малчдаас авсан даатгалын хураамжаас бүрдүүлсэн хураамжаар нөөцийн сан үүсгэж, түүнээс нөхөн төлбөр олгодог гэж ойлгож болно. Өнгөрсөн жил бол манайх бол нийтдээ 7 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг дээд түвшний буюу 2 дугаар босго үзүүлэлт давсан дээд түвшинд нөөц сангаас олгосон. Энэ юу гэсэн үг вэ гэхээр тэр хэмжээгээр “Үндэсний давхар даатгал” компани дээр байгуулагдсан дээд түвшинд хохирлын нөөц сангаас хохирлыг нөхөн төлж байгаа гэж ойлгож болно. Энэ болохоор үндсэндээ төрийн өмчийн давхар даатгалын компанийн өөрийн үйл ажиллагаагаар бий болгосон нөөцийн сангаар дээд түвшний хохирлыг нөхөн төлж байгаа.

**Б.Бейсен:** Ганбаатар гишүүн тодруулъя.

**Г.Ганбаатар:** Тэгэхээр яах вэ, яг энэ чиглэлийн бас сайн туршлага байна уу. Манай энэ нөхцөлд тохирсон гэсэн асуултад хариулсангүй 1 дүгээрт нь.

2 дугаарт нь сая Дундговь аймгийн сумдаар баруун талын хэдэн сумдаар нь явж байгаад ирлээ. Бас л цаг хүндэрчихсэн. Эрдэнэдалай, Адаацаг, Сайхан-Овоо бол 20-30 см ерөөсөө мал идэх юмгүй болчихсон байна. Нийт улс орон даяар ч гэсэн 2023 оны өвлийнх шиг айхтар гамшиг биш юм гэхэд нэлээн хүндрэлтэй болох юм шиг. Тэгэхээр хамгийн гол нь иргэд малчид даатгалд хандах хандлага нь өөрчлөгдөж байна уу. Та нар ер нь энэ даатгалынхаа үйл ажиллагааг сурталчлах, маркетингийнхаа зардал ч гэдэг юм уу, иргэдэд ойлгуулах чиглэлээр ер нь хэр юм хийдэг юм. Сая яах вэ, нөхөн олговор олголоо гээд ярьж л байна. 2023 оны эцсийнх

шиг биш юм гэхэд энэ өвөл нэлээн хүнд болоход хөдөө аж ахуйн салбарт эрсдэлийг бууруулах чиглэлийн ажлууд гайгүй хангагдсан уу.

**Б.Бейсен:** 5 номерын микрофон хариулъя.

**Б.Жавхлант:** Үндсэндээ олон улсад хэрэгжиж байгаа туршлага бол хөдөө аж ахуйн салбарт индексэд суурилсан буюу параметрик даатгалын тогтолцоо олон улсад хэрэгждэг ийм тогтолцоотой. Тэгээд яг түүн дээр нь индекс нь олон төрлийн индекс байдаг. Цасны индекс, хүйтрэлийн индекс гэх мэтчилэн олон төрлийн индекс байдгаас Монгол Улсад тохирох нь том малын зүй бусын хоригдол юм байна гэж тооцоод, энэ том малын зүй бус хорогдолд суурилсан индексийг олон улсын туршлагыг харж нэвтрүүлсэн ийм түүхтэй юм байна лээ. 2023-2024 оны зудын дараа “Үндэсний давхар даатгал” компани даатгалын компаниудтайгаа хамтраад 16,8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг 22 мянган малчин өрхөд олгосон. Түүнээс хойш 2025 оны энэ жилийн борлуулалтын дүнг аваад үзэх юм бол өнгөрсөн жилийн мөн үеийнхээс харьцуулах юм бол 15 орчим хувиар хамрагдалт нэмэгдсэн тоон үзүүлэлт харагдаж байгаа. Тэгэхээр зэрэг үндсэндээ бол нөхөн төлбөрийг олгосон мэдээ бол бас малчдад бид нар даатгуулсан малчид болгондоо хүргэхээс гадна жил болгон “Үндэсний давхар даатгал” компани даатгалын компаниудтайгаа хамтраад аймаг болгонд даатгалын төлөөлөгчдөөрөө дамжуулж сурталчилгаа хийх, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээг ашиглаж энэ нөхөн төлбөр болон даатгалын ач холбогдлын талаарх энэ сурталчилгааг биечилсэн байдлаар болон энэ олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цахим байдлаар сурталчилгааг бол хийж хэрэгжүүлж байгаа. Үндэсний давхар даатгалын компани одоогийн байдлаар 4,9 тэрбум бум төгрөгийн даатгалын хураамж цуглуулснаас олон улсын давхар даатгал дээр эрсдэлээ даатгуулаад нийтдээ 170 орчим тэрбум төгрөгийн даатгалын хамгаалалтыг хамгийн дээд түвшинд авах байдлаар олон улсын давхар даатгалын хамгаалалтаа бүрдүүлчихсэн. Хамтын эрсдэлийн сангаа байршуулчихсан. Бүх нөөцийн сангуудаа бүрдүүлчихсэн явж байгаа. Энэ жилийн хувьд болохоор Сангийн яам буюу манай хувьцаа эзэмшигчдийн зүгээс эрсдэлийн дунд түвшин, дээд түвшний нөөцийн санг 2024 оны жилийн эцсийн байдлаар шавхсан байсныг нөхөж бүрдүүлсэн энэ ажлыг өнгөрсөн 4 дүгээр сард хийсэн.

**Б.Бейсен:** Болсон уу. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч, Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

13.00 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*